



Мөнгөн усны хэрэглээ зайлшгүй зүйл биш! Бидний өмнөх үеийнхэн ийм үйлдэл хийж байгаагүй. Ирээдүй маань ч хийхгүй гэдэгт итгэлтэй байна. Тэгэхээр бид үүнийг одоохон зогсоох ёстой. Үр удам, хойч үеийхнийхээ эрүүл мэндийг зорин байж өнөөдөр таван төгрөгний ашиг олоо гэхэд маргааш ч хүрээд ирж болзошгүй тэр гай зовлонг бид юугаар ч нөхөж чадахгүй гэдэг л аймшигтай.

Өнөөдөр 1990-ээд он биш. Манай улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэний дараахан улс даяараа жилүүдэд, ядууралд өртсөн тэр цаг үед ард түмний тодорхой нэг давхарга, бүлэг хүмүүс амьдрахын эрхээр эрүүл мэнд, амь насаа

золиослон байж гар аргаар алт олборлож эхэлсэн. Мөн ган, зуд, байгалийн гамшгийн улмаас олон малчин өрх амьжиргааны эх үүсвэр болсон малаасаа салсан нь нөлөөлсөн бол өнөөдөр нөхцөл байдал өөрчлөгдөж иргэд маань байнгын найдвартай орлого, амьжиргааны эх үүсвэртэй болохыг зорьж байна. Дэлхийд газар нутгийн хэмжээгээр эхний 20 орны тоонд багтдаг 3 сая гаруйхан хүнтэй манай оронд найдвартай орлого, амьжиргааны эх үүсвэрүүд олон бий. Та бид сонголтоо зөв хийгээд ажиллаад эхлэхэд л байдлыг өөрчилж эрсдэлгүй, баталгаатай, аз жаргалтай ирээдүйд хамтдаа хүрч чадна.

Гар аргаар алт олборлоход далдуурашиглаж байгаа мөнгөн усыг хэрэглээнээс гаргахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Даян Дэлхийн Байгаль Орчны Сангийн Жижиг Төслийн Хөтөлбөрөөс хэд хэдэн жижиг төслүүдийг Баянхонгор, Говь-Алтай, Өвөрхангай, Өмнөговь, Төв, Сэлэнгэ, Хэнтий аймгуудын зарим сумдыг хамруулан 2019 оны хавраас хэрэгжүүлж эхэлж байгаа тул Та бүхэн доорхи хаягаар бидэнд хандаж өөр төрлийн ажил үйлчилгээ, бизнесийн сургалтуудад хамрагдах, зөвлөгөө, арга зүйн тусламж дэмжлэг авах бүрэн боломжтой.



МӨНГӨН УСНЫ АЮУЛ



Манай хаяг: Даян Дэлхийн Байгаль Орчны Сангийн Жижиг Төслийн Хөтөлбөр, НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, НҮБ-ын байр, НҮБ-ын гудамж-14, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-14201, Монгол улс.
Утас: 70112883

Цахим шуудан: ganbaatar.bandi@undp.org;
naranbarav.gankhuuyag@undp.org

Иргэн Таны болон хайртай хүмүүсийн тань эрүүл мэнд, амь нас хэдхэн грамм алтнаас хямдхан гэж үү?



Мөнгөн ус нь хүний бие организмд ороод төв мэдрэлийн систем, бамбай бүлчирхай, бөөр, уушиг, дархлааны систем, нүд, буйл, арьсыг гэмтээдэг аюултай. Хамгийн аймшигтай нь мөнгөн ус тархи, мэдрэлийн тогтолцоог эргэн сэргэшгүй гэмтээж хэдэн үеэр нь удамших аюулыг дагуулдагт оршино.

Гар аргаар алт олборлоход далдуур ашиглаж байгаа метал мөнгөн ус нь гялалзсан мөнгөлөг өнгөтэй, тасалгааны хэмд шингэн хэлбэрт оршдог цорын ганц металл бөгөөд маш амархан ууршиж хүний эрүүл мэндэд онцгой хортой, аюултай нөлөө үзүүлдэг. Мөнгөн усны уур нь хүний биед амьсгалын замаар болон

арьсны салстаар дамжин нэвтрэн ордог бөгөөд дээш дэгддэггүй “хүнд” хий тул бага насны хүүхдийн тоглох, амьсгалах түвшинд ихээр агуулагддаг. Нөгөөтэйгүүр хүүхэд, том хүнээс илүү хурдан амьсгалдаг тул мөнгөн усны уураар илүү их хорддог байна.

Монгол улсын Засгийн газар 2007 онд мөнгөн усыг ашиглах, импортлохыг хориглох, хязгаарлах шийдвэр гаргасан. Гэтэл зарим газарт мөнгөн усны хэрэглээ далд хэлбэрт шилжиж иргэдийн, ялангуяа ирээдүй хойч үеийнхний эрүүл мэндэд аюул учруулсаар байна. Дээр нь мөнгөн устай хаягдлаа ил задгай асгаснаас орчныхоо хөрс, газар, шороо, агаар, хүн, мал гээд бүгдийг хордуулж байна.

Ганцхан грамм мөнгөн ус 20 га газарт тархаж, аюултай нөхцөл байдлыг үүсгэдэг байна.

Энэ нь мөнгөн усыг нууцаар хэрэглэж буй иргэн зөвхөн өөрийн гэр бүлээ төдийгүй ойр хавийнхаа иргэдийг хүрээлэн байгаа орчинтойгоо хамт бохирдуулан аюулд учруулж байна гэсэн үг. Нөгөө талаас иргэд маань сонор сэрэмжтэй байж мөнгөн ус хэрэглэж байж болзошгүй сэжигтэй тохиолдол ажиглагдвал хууль,

хяналт шалгалтын байгууллагад хандах нь зүйтэй. Учир нь нэг хүний өнөө маргаашийн жаахан ашгийн төлөөх хууль бус үйлдэл нь магадгүй бүхэл бүтэн сумын төвийн иргэдийн ирээдүйн хувь заяанд ч нөлөөлж болох нөхцөл байдал үүсэх боломжтой юм. Бид Монгол улсын 1992 оны шинэ Үндсэн хуульд “...байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн” хэмээн заасан байдгийг санаж явах хэрэгтэй.

ой санамжаа алдах

оюун ухаан самуурах

үүртэй омгolon болох

